


НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Биелэлт баталгаажуулсан:

Даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

(албан тушаал)



Төсвийн Шууд захирагч

/Х.ЭРДЭНЭБИЛЭГ/

2021.12.15

(огноо)

Биелэлт хянасан:

Захиргаа, санхүүгийн
Хэлтсийн дарга

(албан тушаал)

A handwritten signature in black ink, likely belonging to the Head of the Department of Finance and Accounting.

(гарын үсэг)

Нэгжийн дарга

/Ч.ШИНЭЧИМЭГ/

2021.12.15

(огноо)

Биелэлт нэгтгэсэн:

Дотоод ажил, сургалт
хариуцсан ажилтан

(албан тушаал)

A handwritten signature in black ink, likely belonging to the person in charge of internal work and training.

(гарын үсэг)

/Ц.ҮРЭЛМАА/

2021.12.15

(огноо)

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв (мян.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	ХШҮ- ний гүйцэт- гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
1.1	Зорилт 1. Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах	8.951.522.4	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100	Байгууллагын дүрмээр хүлээсэн 7 чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх 10 арга хэмжээний хэрэгжилтийг 91%-ийн гүйцэтгэлтэй хангаж ажиллалаа.	91%
1.1.1	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудад нягтлан бодох, санхүү, бүртгэлийн үйлчилгээг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч, нярваар дамжуулан иж бүрнээр үзүүлэх	4.489.522.0	Үйлчилгээ үзүүлэх агентлагийн тоо	12	12	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч 12 агентлагийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээг агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч 7, агентлаг хариуцсан 6 нярваар дамжуулан ямар нэгэн гомдол саналгүй иж бүрнээр үзүүлэн ажиллалаа. Тайлант хугацаанд буюу 12 агентлагийн хэмжээнд 2020 оны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар аудитын газраас 4 акт, 7 албан шаардлага, 40 зөвлөмж өгсөн. Дээрх үзүүлэлтийг бууруулж ажиллахаар зорилт тавин ажиллаж байна.	95%
1.1.2	Байгууллагын 2021 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, өр авлагагүй ажиллаж, санхүүгийн тайлан мэдээг хугацаанд нь гаргаж, эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулан, нягтлан бодох бүртгэлийг оновчтой зохион байгуулж, ажилтан, албан хаагчдын цалин хөлсийг цаг тухай бүр нь олгох, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Өр, авлагагүй ажилласан байх	Өр, авлагагүй ажилласан	Өр, авлагагүй ажиллах	ННҮГ-ын ажилтан, албан хаагчдын сар бүрийн НДШ төлөлтийн тайланг дараа сарын 5-ны дотор ЧД-ийн НДХэлтэст 12 удаа явуулж баталгаажуулан ажиллаж байна. Нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтэст татварын тайланг 4 удаа тайлагнан ажилласан. Гэрээт байгууллагуудын ашиглалтын тооцоог сар бүрийн эхэнд нэхэмжлэхээр хүргүүлж, орлого төвлөрүүлэлтэд тулгалт хийж, нийт 12 удаа ebarimt-д сар бүрийн орлогыг шивж бүртгэл хөтлөн тайлагнасан. Мөн ажилтан, албан хаагчдын хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн бодолт бичилтийг хийж, тухай бүр хянуулан ажилласан. Тайлант хугацаанд 2021 оны 12-р сарын 07-ны өдрийн байдлаар НЗДТГ-ын цайны газар 23877.0 мян.төг, Хангарди ордны зоогийн газар - 195856.0 мян.төг, УБ чуулгын цайны	100%

1	2	3	4	5	6	7	8
						газар - 226298.4 мян.төг-ний орлогыг тус тус төвлөрүүлсэн ба тус газар нь 2021 онд өр, авлагагүй ажиллалаа.	
1.1.3	Нийслэлийн засаг захиргааны байрууд, Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн инженерийн байгууламжийн хэвийн найдвартай, жигд ажиллагааг хангаж ажиллаж, гэрээний дагуу ашиглалт, үйлчилгээний төлбөрийг төвлөрүүлэх	3.257.463.0	Төвлөрүүлсэн орлогын мөнгөн дүн	322.839.4	352.253.3	НЗЗ-ны 5-н байранд байрлах Нийслэлийн нутгийн захиргааны 34 агентлагтай “Байр ашиглалтын гэрээ” болон “Гүйцэтгэх гэрээ” байгуулан гэрээний дагуу ажил, үйлчилгээг үзүүлж ажилласан ба гэрээт байгууллагуудын ашиглалт, үйлчилгээний төлбөрийн тооцоог сар бүрийн эхэнд нэхэмжлэхээр хүргүүлж, орлого төвлөрүүлэлтэд тулгалт хийн тооцоо нийлсэн ба 95 хувьтай, орлого төвлөрүүлсэн байна. Тайлант хугацаанд НЗЗ-ны 5-н байр, НҮНТ-ийн 4-н салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төвийн ус, дулаан, цахилгаан, мужааны засвар үйлчилгээ, инженерийн байгууламжийн хэвийн найдвартай, жигд ажиллагааг ханган ажиллалаа. Цахилгаан, сантехникийн эвдрэл гэмтэл, мужааны үйлчилгээтэй холбоотой нийт 4705 дуудлага ирснийг шуурхай барагдуулж ажилласан ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 57%-иар өссөн үзүүлэлттэй байна.	100%
1.1.4	НЗЗ-ны байруудын аюулгүй байдлыг хангах, камержуулалтыг сайжруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх	86.400.0	Байруудад гарсан зөрчил	Байруудад аюулгүй байдлын зөрчил гаргаагүй	Байруудад аюулгүй байдлын зөрчил гаргуулахгүй ажиллах	НЗЗ-ны байруудын аюулгүй байдалд жижүүр, харуул хамгаалалтын ажилтнууд 24 цагийн камерын хяналт тавьж ажилласан ба тайлант хугацаанд харуул, хамгаалалттай холбоотой зөрчил, дутагдалгүй ажилласан. Байруудын 13 хяналтын камер, 2 дэлгэцэд засвар үйлчилгээг хийж, хэвийн ажиллагааг ханган ажиллалаа. НЗЗ-ны байруудад байх хяналтын камер нь аналог системтэй сэлбэг олдохгүй, дүрсний чанар муу тул сүүлийн үеийн дүрсний чанар сайн IP камер болгон шинэчлэхээр тооцоо судалгааг гаргаж, цаашид шийдвэрлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	80%
1.1.5	Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын ажилтан, албан хаагчдыг хамгаалах багаж хэрэгслээр хангаж, хөдөлмөрийн аюулгүй	-	Хөдөлмөр хамгааллын зөрчил	Зөрчилгүй ажилласан	Зөрчилгүй ажиллах	Тайлант хугацаанд ажилтнуудыг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны өдөр тутмын зааварчилгаагаар хангаж ажилласан ба энэ хугацаанд хөдөлмөрийн аюулгүй байдал	100%

1	2	3	4	5	6	7	8
	ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах					алдагдсан зөрчил гараагүй байна. Мөн ажилтан, албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэх үедээ зайлшгүй баримтлах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэм хэмжээг чанд сахиж, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, ажиллах чадвар, эрүүл мэндээ хэвээр хадгалах, эрүүл аюулгүй нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2021 оны 11-р сарын 08-ны өдрөөс 2021 оны 11-р сарын 12-ны өдрийг дуустал “Эрүүл, аюулгүй ажлын байр” сэдэвт аяныг зохион байгууллаа. Тус аяны хүрээнд нийт 230 ажилтанд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өдөр тутмын заавар, зөвлөмжийг өгч, мөн эрүүл, аюулгүй ажиллах зөвлөмж, ус, цахилгаанаа хэмнэх уриалга бүхий стикер /наалт/, мужаан, цахилгаанчин, сантехникийн слесарийн ажлын байрны аюулгүй ажиллах өдөр тутмын зааварчилгаа зэргийг багтаасан материалыг байр тус бүрт бэлтгэн хүлээлгэн өглөө. Мөн Монголын цахим институт ТББ-гын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан бэлтгэх ХАБЭА-н ажилтны ажиллах эрхийн хугацаагүй лицензтэй сургалтад 1 албан хаагчийг хамруулсан.	
1.1.6	Нийслэлийн засаг захиргааны 1, 2, 5 дугаар байруудын хурлын заалны ашиглалтыг сайжруулж, тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай, жигд ажиллагааг хангах	-	Зохион байгуулагдсан хурлын тоо	949	1000	НЗЗ-ны байруудын хурлын заалны тоног төхөөрөмжийн ажиллагааг бүрэн хангаж, аливаа хурал, шуурхай, зөвлөгөөн, арга хэмжээний хэвийн явагдах нөхцөл бололцоог бүрдүүлэн ажилласан. Тайлант онд НИТХ-ын ээлжит хуралдаан 13, НЗД-ын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн 42 удаа, НЗД-ын зөвлөлийн хурал 16 удаа, ЗАА-ны шуурхай 1, шагналын арга хэмжээ 20 бусад хурал 519 удаа тус тус болсон. Тайлант хугацаанд нийт 611 удаагийн хурлын заал, танхимуудын захиалгыг хүлээн авч, үйлчилгээний бэлтгэл ажлыг бүрэн хангаж, ямар нэгэн зөрчил, доголдолгүй хэвийн жигд ажиллагааг хангаж ажиллаа. Энэ нь 2020 онтой харьцуулахад 64%-иар буурсан нь цаг үеийн нөхцөл байдлын улмаас хурал зохион байгуулагдаагүйтэй холбоотой байна.	70%

1	2	3	4	5	6	7	8
1.1.7	НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд цэвэрлэгээ, үйлчилгээ, ариутгалыг стандарт, зааврын дагуу чанартай хийх	164.315.4	Цэвэрлэгээ, үйлчилгээ, ариутгал хийх талбайн хэмжээ	47.503.74 м2	47.503.74 м2	Тайлант хугацаанд НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн нийт 47.503.74 мкв талбайд өдөр тутмын ажлын өрөөний цэвэрлэгээ, үйлчилгээг 5476 удаа, 14 хоногт тутам хийгдэх хуваарьт их цэвэрлэгээний давтамжийг нэмэгдүүлж 7 хоног тутам 645 удаа тус тус хийж гүйцэтгэсэн. Байруудын гадна орчны 50 метр хүртэлх талбайн цас, мөс цэвэрлэх, ногоон байгууламжийн арчилгаа, дээврийн цэвэрлэгээг нийт 140 удаа зохион байгууллаа. Тайлант хугацаанд коронавирусын эсрэг хариу арга хэмжээ авах ажлын хүрээнд НЗЗ-ны байруудад 5272 удаагийн ариутгал, халдваргүйтэл хийж гүйцэтгэсэн ба энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 73.2%-иар өссөн үзүүлэлттэй байна. Мөн НЗЗ-ны байруудад коронавирусын халдварын тохиолдол илрэх бүрт мэргэжлийн байгууллагаар 337 удаагийн голомтын ариутгалыг хийлгэж ажиллалаа.	100%
1.1.8	Эрүүл ахуйд нийцсэн зоогийн үйлчилгээг төрийн албан хаагчдад үзүүлж, хоол цайны үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлагыг хангаж ажиллах, төлөвлөгөөт орлогыг төвлөрүүлэх	763.057.6	Орлогын мөнгөн дүн	479.647.1	523.347.8	НЗЗ-ны 1 дүгээр байр буюу Тамгын цайны газар, 2-р байр буюу Хангарди зоогийн газар, 5-р байр буюу Улаанбаатар чуулгын цайны газарт хадгалалтын горимын дагуу хадгалсан, эрүүл, чанартай түүхий эд материалаар хоол үйлдвэрлэлийг явуулж, үйлчилгээний стандартын дагуу өдөр тутмын зоогийн үйлчилгээг нийт 57840 орчим хүнд үзүүлж ажиллалаа. Зоогийн газрын хоол үйлдвэрлэл хэрэглэгдэж буй ундны усны шинжилгээг 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр НМХГ-ын лаборатори руу ундны уснаас дээж явуулж 05-р сарын 05-ны өдрийн шинжилгээний хариугаар MNS 0900:2018 стандартын шаардлага хангаж баталгаажсан байна. Зоог, цайны газруудад шавьжгүйтгэл, ариутгал, халдваргүйжуулалт 10 удаа хийж ажилласан ба зарим тоног төхөөрөмж, цахилгаан хэрэглэл, шаазан эдлэлийг шинэчилж үйлчилгээндээ ашиглаж байна.	87%

1	2	3	4	5	6	7	8
						Энэ онд буюу 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар зоог, цайны газрын үйл ажиллагаагаар төвлөрүүлсэн орлогын хэмжээ 446.031.4 төгрөг байгаа нь цаг үеийн нөхцөл байдлын улмаас зорилтот түвшинд хүрээгүй байна.	
1.1.9	Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж буй хүндэтгэлийн хүлээн авалт, хурлын цайны завсарлага, хээрийн үйлчилгээний бэлтгэл ажлыг бүрэн хангаж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх, төлөвлөгөөт орлогыг төвлөрүүлэн ажиллах	190.764.4	Орлогын мөнгөн дүн	119.911.7	130.836.9	Тайлант хугацаанд Нийслэлийн 382 жилийн ойн баярын хүрээнд үе үеийн Нийслэлийн удирдлагуудад хүндэтгэлийн үйл ажиллагаа, Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутагт байрлах гэрэлт хөшөөнд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд нийт 200 гаруй хүнд тус тус хоол, зоогийн үйлчилгээг хээрийн нөхцөлд чанарын өндөр түвшинд үзүүлж ажилласан. Тайлант хугацаанд заалаар үйлчлэх зоогийн хүлээн авалтыг 129 удаа, цай завсарлагын үйлчилгээг 40 удаа, хээрийн болон зөөврийн үйлчилгээг 6 удаа тус тус үзүүлсэн байна. Хурлын цай завсарлага, хүндэтгэлийн хүлээн авалтын үйлчилгээг 5390 хүнд шуурхай чанартай үзүүлж ажилласан ба үйлчилгээтэй холбоотой санал гомдол гараагүй байна.	90%
1.1.10	Бодлогын болон захирамжлалын баримт бичгийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг хугацаанд нь тайлагнаж ажиллах	-	Бодлогын болон захирамжлалын баримт бичгийн Хэрэгжилтийг тайлагнасан тоо	8	8	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 9 заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020-2025 оны хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4 заалтад нийцүүлэн ажиллахаар хяналтад авч хэрэгжилтийг ханган ажиллалаа. Бодлогын баримт бичгийн явцад хяналт-шинжилгээ хийхэд 2021 онд хүрэх түвшин 95%-ийн гүйцэтгэлтэй байна. Монгол Улсын 2 хуулийн 9 заалт, Засгийн газрын 8 тогтоолын 22 заалт, Нийслэлийн засаг даргын 10 захирамжийн 12 заалт, НЗД-ын зөвлөлийн хурлын 3 тэмдэглэлийн 11 заалтыг тус тус хяналтад авч хэрэгжилтийг ханган түүнд тогтмол хяналт тавьж ажиллалаа. Тайлант хугацаанд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 97%-ийн биелэлттэй байна.	96%

1	2	3	4	5	6	7	8
Хоёр. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
2.1	Зорилт 1. Байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагааг зохион байгуулах	90.138.0	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100	Байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагааг зохион байгуулах зорилтын хүрээнд төлөвлөсөн 4 арга хэмжээг 99.5%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажиллалаа.	99.5%
2.1.1	Ажилтан, албан хаагчдын хувийн хэргийг бүрдлийг хангах, холбогдох судалгааг гаргах	-	Ажилтан, албан хаагчдын хувийн хэргийн тоо	302	304	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолын дагуу ажилтан, албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэх ажлын хүрээнд шинээр томилогдсон 50 ажилтан, албан хаагчид шинээр хувийн хэрэг үүсгэж, холбогдох баримт бичгийг бүрдүүлж, хувийн хэргийн бүрдлийг ханган ажилласан. Мөн байгууллагын 291 ажилтан, албан хаагчдын хувийн хэргийг тухай бүр нь баяжуулалт хийж ажиллалаа. Тайлант хугацаанд хүний нөөцийн чиглэлээр холбогдох нийт 14 судалгааг шинэчлэн нэгтгэсэн.	100%
2.1.2	Сул орон тоог холбогдох хууль, журмын дагуу нөхөх	-	Хүний нөөцийн бүрдүүлэлтийн коэффициент	0.6	0.6-аас ихгүй байх	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр ажлын байрны сул орон тооны зарыг байгууллагын цахим хуудас www.khangardi.mn болон зарын нэгдсэн цахим хуудас www.unegui.mn , www.biznetwork.mn байгууллагын мэдээллийн самбарт тус тус тогтмол байршуулж ажиллалаа. Мөн Хөдөлмөр эрхлэлтийн газар болон дүүргүүдийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэстэй хамтран ажиллалаа. Тайлант хугацаанд ажлын байрны 12 ажлын байрны 60 сул орон тоонд 115 ажил горилогч материалаа ирүүлж, нөөцөд бүртгэгдсэн ба анкет, хувийн хэргээс сонгон шалгаруулалт хийж, 50 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ хийлээ. Мөн үйлчлэгч Н.Дэлгэртуяаг угтах үйлчилгээний ажилтнаар, угаагч П.Алимааг бэлтгэгч тогоочоор, бэлтгэгч тогооч Ц.Буян-Эрдэнийг тогоочоор дэвшүүлэн томилсон байна. Тайлант онд хүний нөөцийн бүрдүүлэлтийн коэффициент 0.5 байна.	100%

1	2	3	4	5	6	7	8
2.1.3	Ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг улирал бүр дүгнэж, цаашид авах арга хэмжээний саналыг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэх	-	Ажилтан, албан хаагчдын ур чадвар, үр дүнг дүгнэсэн тоо	8	8	<p>Тайлант хугацаанд газрын даргын 2020 оны А/36 дугаар тушаалаар байгууллагын үнэлгээний багийг байгуулж, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоол, холбогдох бусад журмын дагуу давхардсан тоогоор 791 ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг 4 удаа дүгнэж, үр дүнгийн урамшууллыг улирал бүр тооцон олгож ажилласан.</p> <p>Мөн газрын даргын 2021 оны А/08, А/26, А/52 дугаар тушаалуудаар ажилтан, албан хаагчдын 2021 оны 1, 2, 3 дугаар улирлын ур чадварыг дүгнэх ажлын хэсгийг тус тус байгуулж, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, холбогдох бусад журмын дагуу ур чадварын нэмэгдлийг сар бүр тооцон олгож байна. Үүнд:</p> <p>1-р улирлын байдлаар нийт 271 ажилтан, албан хаагч дүгнэгдэхээс 270, 2-р улирлын байдлаар нийт 264 ажилтан, албан хаагч дүгнэгдэхээс 258; 3-р улирлын байдлаар нийт 267 ажилтан, албан хаагч дүгнэгдэхээс 263 ажилтан, албан хаагчийн ур чадварыг тус тус дүгнэж, ур чадварын нэмэгдлийг тооцон олгосон байна. Үүнээс 1-р улиралд - 1, 2-р улиралд - 6, 3-р улиралд - 4 ажилтан, албан хаагч тус тус шинээр орсон шалтгаанаар дүгнэгдэх боломжгүй гэж үзсэн байна.</p>	100%
2.1.4	Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын 2021-2024 онд хэрэгжүүлэх хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах	90.138.0	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	0	25	<p>Газрын даргын 2021 оны А/20 тушаалаар “Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын 2021-2024 онд хэрэгжүүлэх хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг батлуулсан. Тус хөтөлбөрийн хүрээнд 2021 онд хэрэгжүүлэх Сургалтын төлөвлөгөө, Нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг тус тус батлуулж хэрэгжилтийн ханган ажилласан. Тайлант хугацаанд нийт 24 удаагийн сургалтад давхардсан тоогоор 525 ажилтан, албан хаагч хамрагдсан. Мөн дээд газраас болон бусад байгууллагаас зохион байгуулагдсан 59 удаагийн сургалтад давхардсан тоогоор 797 албан хаагчийг ажил үүргийн чиглэлийн дагуу хамруулсан. Үүнээс 10 удаагийн сертификаттай сургалтад давхардсан</p>	98%

1	2	3	4	5	6	7	8
						тоогоор 92 албан хаагчийг хамруулсан байна. Мөн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу хоол, унааны хөнгөлөлт, нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмж, урамшуулал зэрэгт нийт 692.265.394 төгрөгний буцалтгүй тусламж олгосон байна.	
2.2	Зорилт 2. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх	18.590.0	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100	Тус зорилтыг хангаж ажиллахаар 9 арга хэмжээг төлөвлөсөн ба хэрэгжилтийг тодорхой үр дүнд хүрсэн үнэлгээтэй хэрэгжүүлэн ажиллалаа.	93%
2.2.1	2021 онд байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Авлига, ашиг сонирхлын зөрчил	Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан	Авлига, ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх	Тус газрын хэмжээнд хэрэгжүүлэх авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдөр газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж буй авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд хүний нөөцийн ил тод байдал, төсөв санхүүгийн ил тод байдал, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, энэ талаарх тайлан, мэдээг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байршуулсан. Тайлант хугацаанд ашиг сонирхлын зөрчил гаргасан ажилтан, албан хаагч байхгүй болно.	100%
2.2.2	Байгууллагын ажилтан, албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйг сахиулах, харилцаа хандлагыг дээшлүүлэх, зөрчлийг өмнөх оныхоос ихгүй байлгах	-	Зөрчлийн коэффициент	0.025	0.021-оос ихгүй байх	Тайлант хугацаанд Ёс зүйн зөвлөл нь 10 ажилтан, албан хаагчид холбогдох гомдол мэдээллийн дагуу 6 удаа хуралдаж, холбогдох шийдвэрийг гаргаж ажиллалаа. Үүнд: 8 ажилтан, албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах саналыг газрын даргад уламжилсан ба 2 ажилтанд хурлын тэмдэглэлээр сануулах арга хэмжээг тус тус авч ажилласан. Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдаас ёс зүйн зөрчил гараагүй ба зөрчил гаралтын коэффициент 0 байна.	100%
2.2.3	Байгууллагын үйл ажиллагаа, ажилтан, албан хаагчдын чиг үүргийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дотоод хяналт шалгалтын ажлыг зохион	-	Үйл ажиллагаанд гарсан зөрчил, дутагдал	Үйл ажиллагаа хэвийн явагдсан		Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн холбогдох 3 заалтад нийцүүлэн хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-	100%

1	2	3	4	5	6	7	8
	байгуулах зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлж ажиллах					2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгжүүлэх төлөвлөгөөний манай байгууллагад хамаарах 8 заалтын хэрэгжилтийн явц, Хууль тогтоол, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, захирамжлалын баримт бичгийн хэрэгжилт, мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт, Байгууллагын болон нэгжүүдийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2021 оны биелэлтэд тус тус хяналт-шинжилгээ хийж, дүнг газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулж холбогдох арга хэмжээг авч ажиллалаа. Тайлант хугацаанд нийт Засаг даргын 16 захирамжийн 16 заалт, НЗДЗөвлөлийн хурлын 3 тэмдэглэлийн 11 заалт хүрээнд тайлан мэдээг бэлтгэж, сар улирлаар 1-3 удаагийн давтамжтайгаар заасан хугацаанд www.monitoring.ulaanbaatar.mn цахим сайтад байршуулахын зэрэгцээ НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст цахим болон цаасан суурьтайгаар хүргүүлж ажилласан.	
2.2.4	Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйлчилгээний чанарын талаарх сэтгэл ханамжийн судалгааг авч, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллах	-	Сэтгэл ханамжийн судалгааны тоо	1	2	Тус газар нь байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, хэрэглэгчдийн санал хүсэлтийг нээлттэйгээр хүлээн авч, хурдан шуурхай шийдвэрлэх зорилгоор сэтгэл ханамжийн судалгааг 2 удаа авахаар төлөвлөдөг. Гэвч цаг үеийн нөхцөл байдлын улмаас 2021 оны эхний хагас жилийн сэтгэл ханамжийн судалгааг аваагүй хойшлуулсан ба сүүлийн хагас жилийн сэтгэл ханамжийн судалгааг НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, Баянхошуу дэд төвд үйл ажиллагаа явуулж байгаа нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдаас 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал хугацаанд цахим болон цаасан хэлбэрээр зохион байгуулсан. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой сэтгэл ханамжийн судалгааг ERP системийн “Судалгаа” цэсээр цахим хэлбэрээр зохион байгуулж нийт 860 ажилтан, албан хаагчид	70%

1	2	3	4	5	6	7	8
						оролцож санал хүсэлтээ өгсөн. Тус судалгаанд оролцогчдын 63 хувь сайн, 31 хувь дунд, 6 хувь хангалтгүй гэж тус тус байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэсэн.	
2.2.5	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг нэмэгдүүлэхгүй байх	-	Өргөдөл гомдлын Шийдвэрлэл -тэд гарсан зөрчил	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн зөрчилгүй ажилласан	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн зөрчилгүй ажиллах	Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдаас нийт 140 өргөдөл ирснийг 100 хувь бүрэн шийдвэрлэж хариуг өргөдөл гаргагчид биечлэн болон бичгээр танилцуулсан. Мөн хугацаанд өргөдөл гомдлын бүртгэл, явц болон шийдвэрлэлттэй холбоотой ямар нэгэн зөрчил гараагүй болно. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног, 20 цаг, 33 минут байна. Байгууллагад ирсэн өргөдлийг хандалтыг төрлөөр нь ангилбал: Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл 20, Захирааны чөлөө хүссэн өргөдөл 16, Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл 44, Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө хүссэн өргөдөл 23, Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл 34, Ажилд шилжих, дэвшин ажиллах тухай өргөдөл 2, Иргэдээс гаргасан санал, хүсэлт 1 байна.	100%
2.2.6	Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд зохион байгуулах, тоон гарын үсгийг албан хэрэгцээнд бүрэн нэвтрүүлэх	8.150.0	Зөрчлийн тоо	1	1	- Нийслэлийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/252 дугаар захирамж “Нийслэлийн байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөх албан хэрэг хөтлөлтийн ажлын нийтлэг журам”, газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/16 тушаалаар баталсан “Албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалтын журам”-ыг байгууллагын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж байна. - Тайлант хугацаанд явсан бичиг 350, ирсэн албан бичиг 346 үүнээс хариутай бичиг 128, хариугүй бичиг 218 байгаа бөгөөд шийдвэрлэлтийн хувь 98.37% байна. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гаргасан даргын тушаал 41, Байгууллагын хүний нөөцийн чиглэлээр гаргасан даргын тушаал 147 тус тус батлагдан гарч хэрэгжилтийг ханган ажилласан болно. -Нийслэлийн Засаг даргын Тамгын газар,	100%

1	2	3	4	5	6	7	8
						<p>Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдээс холбогдох газруудад явуулсан нийт 9367 албан бичгийг тус газрын 2 бичиг хүргэгч шуурхай хүргэж ажилласан байна.</p> <p>Байгууллагын 2020 оны үйл ажиллагаанд нэгжүүдээс үүсч хөтлөгдсөн 70 жил хадгалах 24, байнга хадгалах 76, түр хадгалах 176 буюу нийт 276 хадгаламжийн нэгжийг “Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын архивын дүрэм”, “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын дагуу ангилж нэр төрөл хугацаагаар нь төрөлжүүлсэн.</p> <p>- Тайлант хугацаанд иргэд аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг үндэслэн нийт 93 архивын лавлагаа олгож, хуулбар үнэн тэмдэгт дарж, бүртгэл хөтөлсөн.</p>	
2.2.7	Байгууллагын худалдан авалтад дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг дэмжих	-	Нийт худалдан авалтад дотоодын бүтээгдэхүүн эзлэх хувь	70%	70%-аас доошгүй байх	Байгууллагын зоогийн газрын хүнсний бараа материалын 90 хувийг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг худалдан авч, төрийн албан хаагчдад эрүүл, чанартай бүтээгдэхүүнээр хоол, зоогийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.	100%
2.2.8	НЗЗ-ны байруудад гамшгаас хамгаалах төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулах	-	Гамшгийн эрсдлийн үнэлгээ хийсэн байрны тоо	3	5	Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэсээр батлуулсан байгууллагын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан ба Нийслэлийн засаг захиргааны 3 дугаар байран хана цуурсан байх тул мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулахаар холбогдох байгууллагад албан бичиг хүргүүлсэн.	70%
2.2.9	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цахим хуудас /www.khangardi.mn/ болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулан олон нийтэд ил тодоор хүргэж ажиллах	10.440.0	Цахим хуудас болон мэдээллийн самбарт тавигдсан мэдээний тоо	191	192	Байгууллагын цаг үеийн шинж чанартай мэдээ, мэдээллийг www.khangardi.mn цахим хуудас, пэйж хуудаст 96 удаа, НЗДТГазрын www.ulaanbaatar.mn цахим хуудаст 1 удаа тус тус байршуулан байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажилласан.	100%

1	2	3	4	5	6	7	8
Гурав. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ							
3.1	Зорилт 1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	900.089.0	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0	100	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд нийт 5 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилтийг ханган ажилласан.	87%
3.1.1	Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан холбогдох стандартуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах	-	Хэрэгжүүлж ажиллах стандартын тоо	2	3	<p>-"Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ, үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага" UCS 0202B:2020 стандарт удирдамж арга зүйн баримт бичгийг танилцуулах арга хэмжээний хүрээнд НЗЗ-ны 2-р байрнаас "Бүтээмж" нэртэй 4 гишүүний бүрэлдэхүүнтэй сургалтын багийг байгуулж 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдөр анхны сургалтаа зохион байгуулсан. Тус сургалтаар цэвэрлэгээ үйлчилгээг хэрхэн стандартын дагуу хийж гүйцэтгэх, шинэ ажилтанг бэлдэж сургах талаар мэдээлэл өгсөн бөгөөд өөрсдийн гарын доорх материалаар хийсэн багаж хэрэгслийг танилцуулсан юм.</p> <p>- Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/276 дугаар захирамжаар стандартын удирдамж арга зүйн баримт бичиг болон батлагдсан. "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ, үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага" UCS 0202B:2020 стандарт удирдамж арга зүйн баримт бичгийг нийслэлийн 9-н дүүргийн Тамгын газрын цэвэрлэгээ үйлчилгээ хариуцсан аж ахуйн тасгийн ажилтан, албан хаагчдад сурталчилан таниулах сургалт, семинарыг 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан.</p> <p>-Үйлчилгээний албанаас цэвэрлэгээ үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэхэд шаардлагатай практик ур чадвар олгох, багийн системийг идэвхжүүлэх, ажиллах идэвх оролцоог нэмэгдүүлэх, бүтээлч санаачлагыг дэмжих зорилгоор 2021 оны 12-р сарын 06-ны өдрөөс 10-ны өдрийн хугацаанд "Стандартаа хэвшүүлье, харилцаагаа сайжруулъя" аяныг зохион байгуулсан. Тус аяны хүрээнд 9 удаагийн стандартыг хэвшүүлэх сургалтыг явуулсан.</p>	100%

1	2	3	4	5	6	7	8
3.1.2	Нийслэлийн засаг захиргааны байруудын тохижилт, засварын ажлыг батлагдсан төсөвтөө багтаан гүйцэтгэх	900.089.0	Засварын ажлын тоо	10	15	Тайлант онд НЗЗ-ны 1-р байрны дээвэр, гадна фасад, Хангарди ордны 4-н давхарын зүүн талын шилэн фасадны шил, 16 давхрын шилэн фасадны жийргэвч, НЗЗ-ны 4-р байрны 4 давхарын дээвэр, НЗЗ-ны 5-р байрны В корпусын дээврийг засварын ажлыг тус тус хийж байруудын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллалаа.	100%
3.1.3	Байгууллагын зарим үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх	-	Цахим хэлбэрт шилжүүлэх үйлчилгээний тоо	1	2	Байруудын хурлын заалны захиалгыг цахим хэлбэрээр авч, мэдээллийн ил тод нээлттэй байдал, хэрэглэгчдийн цаг хугацааг хэмнэх зорилгоор нийслэлийн нутгийн захиргааны дотоод удирдлагын систем /ERP/-д шинэ цэс үүсгэхээр холбогдох судалгааг хийж, хэрэгжүүлэхэд бэлэн болсон ба 2022 онд программчилахаар холбогдох зардалыг төсөвлөж батлуулсан.	50%
3.1.4	НЗЗ-ны байрууд, НҮНТ-ын салбарууд, Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний стандарт бүхий орчинг бүрдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах	-	Стандарт орчин бүрдүүлэхэд зохион байгуулсан ажлын тоо	1	2	Тайлант хугацаанд НЗЗ-ны байрууд, дэд төвүүдэд авто зогсоол, орц, гарц, ариун цэврийн ерөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу бүрэн хийж гүйцэтгэсэн.	85%
3.1.5	Засгийн газар, Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссоос гаргасан шийдвэрийн хүрээнд цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах	-	Арга хэмжээ зохион байгуулж буй байр, салбар, дэд төвийн тоо	10	11	Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178, 181, 194, 226 дугаар тогтоол, 2021 оны 43, 45 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 34, 37 дүгээр хурлын тэмдэглэл, УОК-ын даргын 2021 оны 18-р тушаал, Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 16 дугаар хурлын тэмдэглэл, 2021 оны 18 дугаар хурлын тэмдэглэл, НОК-ын 2021 оны 710, 723 дугаар албан бичиг, НОК-ын даргын 15-р тушаал, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1242, 1250, 1320 дугаар захирамж, 2021 оны А/779 дүгээр захирамжийг тус тус үндэслэн тушаал, шийдвэрүүдийг гаргаж хэрэгжүүлэн ажиллалаа.	100%